

## **ДЭ ВАН БА ТҮҮНИЙ ГЭР БҮЛИЙНХНИЙ ХУВЬ ЗАЯА**

*Д.Зоригт\**

Монгол-Зөвлөлтийн цэрэг 1945 оны 8-р сард Шилийн голд орж ирэх үеэр манай холбогдох байгууллагынхан Дэ вангийн гэр бүлийн хүмүүсийг Улаанбаатарт аваачаад байв. Энэ үед манайхан тусгай хүн томилон явуулж, их сургуульд суралцаж байсан хүү Дугарсүрэнгийн захидлыг гэр бүлийнхний нь гэрэл зураг, торго, мөнгөн аяга, хадаг зэрэг бэлгийн хамт Дэ ванд хүргүүлсэн байна. Тэрээр хүүгийнхээ захидлыг үзвэл БНМАУ-ын удирдлагаас түүний ирэхийг ихэд хүсч байгааг дурдаад хэрэв ирвэл манай орны аль ч газарт сууж болно гэснийг дамжуулсан байжээ. Дэ ван энэ үед баруун тийш явж Баянзанданд хүрээд тэнд урьдчилан бэлтгэсэн цахилгаан холбооны хэрэгслээрээ таран байрласан цэргээ удирдахаар төлөвлөж байсны дээр манай улсад бас бүрэн итгэхгүй байсан тул 8-р сарын 18-нд Баянзанданд ирж намайг хүлээ гэж тэдэнд дамжуулахыг хүсээд буцсан байна. Ингээд Төхөмийн сүм рүү явах замдаа тэнд байсан холбооны хэрэгслүүдийг нь Алтан-Очир манай улсад шилжүүлж өгснийг сонсоод горьдлого нь тасарч, ихэд урам хугарав. Тэнд очоод Алтан-Очирыг дуудуулж уулзсанд тэр нь манай улсад очихыг ятгаж гарчээ. Тэгэхэд нь Дэ ван “Одоо үндэстнээ сэргээн мандуулах үйлсийг үүрэглэсэн надаас өөр хэн байх вэ? Би мөн баруун тийш явж Монголын ажлаа эрхлээ гэж төлөвлөж байна. Одоо Монгол улсад очиход хүрвэл хүн бүхэн намайг гэр бүлийнхээ төлөө хувиа бодож, нийтийг хохироосон гэвэл би үг байгаад маргах газаргүй болох биш үү?” гэсэн байна. (5, т 787)

Ингээд тэрээр Алтан-Очир, Түмэндэлгэр, Шоноо нарын хамт мордож, замдаа хоёр хоноод Хар эрэгт очиход хурандаа Чойжил тэргүүтэй манай хүмүүс машинаар тосч авсан байна. Тэд Дотоод явдлын яамны дэд сайд Баяр (жинхэнэ нэр нь Очирбат), төвөөс томилсон Лувсан, таны хүү Дугарсүрэн нар энд удтал хүлээгээд ирэхгүй болохоор буцсан гэж мэдэгдээд түүнийг мөн буцаж болно гэжээ. Дэ ван манайхныг нэлээд сэжиглэж, буцаахгүй байж магад хэмээн эмээж байсан болохоор энэ үгийг сонсоод нэлээд тайвширчээ. Маргааш нь Баяр ирж түүнтэй ярилцахдаа “одоо БНХАУ байгуулагдаж, манай хоёр орон дипломат харилцаа тогтоох гэж байна. Та ямар нэг асуудал байвал Бээжингийн талд хандах нь зүйтэй. Бид бусдын дотоод хэрэгт гар дүрж болохгүй” гэсэн бөгөөд түүнийг хүндэтгэн дайлжээ. Идэж уух зуур Баяр түүнд гэр бүлийнхний нь байдлыг танилцуулахад Дэ

\* Д.Зоригт - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

ван хүүхдүүдэд минь сайн суралцаж, монгол үндэстнийхээ төлөө чармайгаарай гэж дамжуулна уу гэсэн байна. Тэд нэлээд удаан ярилцаж, идэж уун нэлээд согтоцгоосон аж.

Дэ ван ийнхүү ирээд буцахдаа манай улсын талаар бодож байсан урьдын элдэв сэжигтэй бодлууд нь бүрмөсөн үгүй болсон байна. Түүнийг буцаж ирсний дараа Хай Фуцаюнэ манай улс руу явахад Дэ ван Алтан-Очирт захидал явуулж, түүндээ “Би нугаршгүй зоригоор монгол үндэстнийхээ төлөө зүтгэнэ” гэсэн үг оруулсан бөгөөд үүнийг манайханд хүргэж, өөрийгөө ойлгуулах зорилгоор бичсэн байна. Гэтэл манай холбогдох хүмүүс үүнийг нь үзээд Дэ ванг Өвөр Монголын хил хязгаарт үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, хоёр орны харилцаанд зохисгүй байдал буй болгохоос болгоомжлон дахин хүн томилон явуулсан бололтой. Дэ ван Гомбыг манай хил рүү явуулж холбоо бариулахад Баяр нар ирээд хүлээж байгаа гэсэн тул удирдах гол хүмүүсээ цуглуулж, дахин явах тухай асуудлаа тавьж ярилцжээ. Тэрээр энэ удаа явах гэсэн зорилгоо нэг талаар манай улстай холбоо тогтоох, нөгөөтэйгүүр хөлөө эмчлүүлэх шаардлагатай байна гэж тайлбарласан байна. Хуралд оролцсон хүмүүс үүнийг санал нэгтэй зөвшөөрч, хорооны дарга Саграажавд цэргээ авч Дэ ванг хилийн шугам хүртэл гаргаж өгөхийг үүрэг болгожээ.

Тэрээр 1949 оны 12-р сарын 29-нд Цэрэндорж, Түмэндэлгэр нарыг дагуулан Батжаргалан, Гомбо хоёрын хамтаар манай улсын Цагаан толгой гэдэг газарт очихоор мордлоо. Тэднийг очиход Баяр нарын хүмүүс холбооны том машинтай угтан ирж, Дэ ванг машинд суулган Цагаан толгойд очжээ. Баяр маршал Чойбалсан тантай чухал асуудал ярих тул намайг томилон явуулж, таныг Улаанбаатарт авчрахыг даалгасан гэж хэлэхэд нь Дэ ван Хятадын Ардын чөлөөлөх армийн таван төлөөлөгч өөртэй нь уулзахаар ирээд байгаа тул буцах шаардлагатай байгаагаа тайлбарлажээ. Үүнийг нь тэд огт ойшоож үзэлгүйгээр шахалт үзүүлэхэд нь Дэ ван өөрийгөө Улаанбаатарт очих нь хоёр орны гадаад харилцаанд нөлөөлөх эсэхийг бодох хэрэгтэй биш үү гэсэнд “та манай улсад очих л юм бол бусад асуудлыг бид хариуцна” гэсэн байна. (6, т 386)

Дэ ван Чойбалсан өөртэй нь ямар чухал асуудал ярих гэсэн юм бол гэж нэлээд эрэгцүүлэн бодоод үндэстний л холбогдолтой байж таарна гэж таамаглав. Тэрээр “Үүнд хамгийн чухал нь дотоод гадаад Монголыг нэгтгэх асуудал. Энэ асуудалд Чойбалсангийн зөвшөөрөл дэмжлэгийг авах юм бол би санаа амар буцаад цэргээ удирдан баруун тийш явж, Америкийн дэмжлэгт түшиглэн дэлхийн олон орноор явж, гадаад дотоод Монголыг нэгтгэх асуудлыг ухуулан, олон улсын байдалд өөрчлөлт гарахыг хүлээнэ. Чойбалсангийн гадаад Монголын, миний

дотоод Монголын асуудлаархи чармайлт хэдийгээр адилгүй замаар явж байвч ирээдүйд хоёр Монгол нэгдсэн их Монгол улсаа байгуулах болно. Чойбалсан монгол хүний хувьд яасан ч орос хүний эзэмшлийг хүлээхгүй байж, тусгаар тогтнон өөртөө эзэн мэдэх санаатай байлгүй. Үүн дээр над шиг ийм нэгэн хүн гарч ирээд түүнтэй хамсаж хоёр Монголыг нэгтгэх гэж байхад тэр лав дуртай байх... Хэдийгээр намайг илээр дэмжихгүй ч гэсэн дуугай зөвшөөрвөл болчихно. Гоминьданы ноёрхлын хугацаанд Монгол ард улс хэдийгээр тусгаар тогтнолоо тунхагласан боловч хүн ам цөөн, улс гэр ядуу учир Өвөр Монголыг эзлэн авах санаатай байсан. Дундад ард улс байгуулагдсаны дараа Монгол, Дундад хоёр улс адил шинж чанартай орнууд байсан учир Чойбалсан хоёр орны гадаад харилцаанд нөлөөлөхөөс болгоомжлон энэ ажлыг хийхэд бэрхшээлтэй болсон. Харин яг над шиг ийм хүн энэ ажлыг хийвэл зохино.” гэж бодоод очихыг шууд зөвшөөрсөн байна. (4, т 15)

Дэ ван Улаанбаатарт Цэрэндорж, Түмэндэлгэр, Гомбо, Зана нарыг дагуулж ирсэн бөгөөд түүнийг Дотоод явдлын яамны мэдлийн байранд оруулахдаа хэнтэй хамт суухыг нь асуухад хоол хийх хүн Зана хоёр байхад болно гэсэн байна. Ингээд тэд хоорондоо харилцаж чадахаа больж, ДЯЯ-наас Вандан гэдэг хурандааг Дэ вантай байнга харилцаж байхаар томилсон ба ахлах дэслэгч Лувсандоржийг уг байранд байлгахад болжээ. Түүний суух байр тохилог бөгөөд хоол унд сайн, өрөөнд нь Лениний бүрэн боть, Мао Зэдуны сонгомол зохиолын түүвэр зэрэг олон ном тавьсан байлаа.

Нэг удаа Баяр Дотоод явдлын яамны сайд Дуйнхоржав, ЗХУ-ын зөвлөх гэх нэгэн дэслэгч-генералын хамт түүн дээр ирэв. Дуйнхоржав түүнээс цаашид яах бодолтой байгааг нь асуухад “Би эндэх ажлаа дуусгаад буцан очиж үндэстнийхээ ажлыг үргэлжлүүлнэ гэж бодож байна. Хэрэв Дундад улсын эв хамт нам ялалтын эрчин дээрээ надад дарамт учруулвал хүчтэй байсан цагтаа эсэргүүцэл үзүүлнэ” гэхэд тэр их цочиж, гайхсан байдлаар “Чи үнэхээр эсэргүүцнэ гэж үү?” гэсэнд зөвлөлтийн генерал нь “Чи буруу бодож байна. Одоо ХКН-ыг дахин эсэргүүцэж болохгүй. Харин Өвөр Монгол дахь өөрийн нэр хүнд болон ажил үйлсээ ашиглан тунхаг гаргаж, Өвөр Монголын ард түмнийг ХКН-ын удирдлагыг хүлээн авахыг ятгах нь зүйтэй” гэжээ. Тэрээр эцсээ хүртэл тэмцэх зориг эрмэлзлэлтэй байсан тул ЗХУ-ын зөвлөхийн тэр үгийг сонсох хүсэлгүй байлаа. Тэгээд түүнд хандан “Би энэ мэт бодож, ингэж хийхээ тун зөв гэж ойлгож байна” гэхэд генерал тэсч ядсан байдалтайгаар суудлаасаа босч, өрөөн дотор нааш цааш алхаж гарав. Дуйнхоржав түүнд гэр бүлийнхэнтэйгээ уулзаж болохыг хэлээд харин энд ирсэн асуудал чинь туйлын нууц байх ёстой тул тэдэндээ үг алдаж

болохгүйг анхааруулаарай гэв. Маргааш орой нь тэр хоёр мөн ирж Дэ ванг буцалгүй эндээ илээр үлдэж, гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдарвал дээргүй юу гээд энэ асуудлаар Баяртай ярилцаарай гэсэн байна.

Дэ ван энэ үед Мао Зэдун Москвад айлчилсан тухай мэдээг радиогоор сонсоод манай улсын удирдлагаас гуйж байгаад тэнд очиж Маотай уулзаж болох юм гэж бодсон боловч үүнийгээ бүтэхгүй зүйл гэдгийг ойлгов. Монголд үлдчихье гэж бодовч тэнд хоцорсон хүмүүс түүнийг гэр орноо бодоод ажил хэргээ орхилоо гэж ойлгоно гэхчлэн түмэн зүйлийг бясалган шаналж байлаа. Монгол улсад амар тайван амьдрахыг ч мөн хүсч байв. Ингээд Баярт хандаж Горной голд хоцорсон хүмүүсээ Ланьжоуд сууж буй Пэн Дэхуайд тушаан өгвөл ямар вэ гэсэн санаагаа хэлж, тэдэнтэй хэрхэн холбоо барих, Пэн-д захиа бичих боломж бий эсэх зэргийг лавлахын зэрэгцээ цэргээ Монгол улсад авчирвал яах вэ гэж асуулаа. Баяр цэргээ манай улсад авчрах гэдэг нь бүтэхгүй, харин цөөн тооны хүмүүс ирж болно гээд үүнийг удирдлагадаа танилцуулъя гэлээ. Тэгэхэд нь Дэ ван тэдэндээ захидал бичиж, холбогдох хүмүүсийг Хар эрэгт ирүүлэн өөрөө нүүр тулан уулзаж ярилцъя гэсэн санал тавьсанд Баяр удирдлагадаа танилцуулаад зөвшөөрсөн хариу өгөв.

Дотоод явдлын яамныхан хэлсэн ёсоороо Алтан-Очирыг буудалд нь ирүүлж Дэ вантай уулзуулан тэднээр захидал бичүүлжээ. Уг захидалдаа “Монгол цэргийн жанжин штабын хариуцлагатан Ли Шоусинь, Бао Гуйтин, хоёрдугаар дивизийн хариуцлагатан Дүүрэнсан, Тогтох, нэгдүгээр дивизийн хариуцлагатан Сүхбаатар, Номбаатар зэрэг зургаан хүний гурав нь Монгол улсын хил дээрх Цагаан толгойд ирж надтай чухал явдал зөвдөгтүн...” гэж бичсэн байна. (9, т 202) Дэ ван энэ захидлаа Баярт өгөөд манай талаас түүнийг явуулахгүй байх хэмээн болгоомжилж “Горной голд хоцорсон цэргүүдийн хоол хүнс дутагдаж, аргацаах аргагүй болж байгаа. Хэрэв тэд гадагш гарч дээрэм тонуул хийвэл миний хариуцлага нэн хүндэрнэ. Иймээс би өөрөө очиж тэднийг Хятадын Ардын чөлөөлөх цэрэгт тушаан өгөхийн зэрэгцээ өөрийн тэргүүлэгчийн тушаалаа ч огцруулъя. Би эдгээр хэрэг явдлаа хийж дуусмагц Монгол улсад буцаж ирнэ” гэсэн өргөдлөө мөн өгчээ. Үүний нь хариу ч таг чиг болов. Түүний захидлыг аваад Ли Шоусинь, Бао Гуйтин, Сүхбаатар, Дүүрэнсан, Номбаатар, Даш нарын зэрэг хорь гаруй хүн манай улсад ирсэн бөгөөд энэ тухай Дотоод явдлын яамныхан Дэ ванд хэлээгүй тул тэр нөгөөдүүлээ хүлээсээр л байжээ. Манайхан түүнээс таван асуултад дэлгэрэнгүй хариулт өгөхийг шаардаж, Алтан-Очирыг дуудан авчирч бичүүлж авсан байна. Гомбыг явсны дараа түүний хөлийн өвчин хүндэрсэн тул зөвлөлтийн

мэргэжилтэн эмчээр эмнүүлжээ. Энэ үед Баяр түүнийг гэр бүлийнхэнтэйгээ уулзаж болно гэсэн боловч тэр албаны явдлаа шийдвэрлэж дууссаны дараа гэр бүлтэйгээ уулзахад оройтохгүй гэсэн байна. Манайхан ууган хүү Дугарсүрэнг нь түүнтэй хэдэн удаа уулзуулсан боловч Баяр дэргэдээс нь салаагүй тул улс төрийн асуудал ярилцахаас зайлсхийн гэр бүлийн ойр зуурын зүйлээ л ярьж байлаа. Түүнийг хотын байдалтай танилцуулж, кино үзвэр үзүүлэх, хөлийг нь эмчлэх зэргээр нэлээд анхаарал тавьж, халамжилж байсан боловч бүх талаар хянаж байгаа нь мэдрэгдэж байжээ. Түүнд Монголд иймэрхүү байдлаар суучихвал улс төрөөр хөөцөлдөхгүй сэтгэл амар чөлөөтэй байж болмоор ч санагдаж байв. Гэтэл түүнийг анхаарч, харгалзах нь өдрөөс өдөрт муудаж эхэлсэн байна. Дэ ван албаны явдал үр дүнгүй, урагш томилон явуулсан Гомбоос сураггүй байгаа энэ чөлөөтэй үеийг ашиглаад гэр бүлийнхэнтэйгээ уулзъя гэсэн хүсэлт тавьсанд Баяр хүлээж байгаад больё гэжээ.

Хурандаа Вандан 1950 оны 2-р сарын 27-нд Дэ ванг жанжин Сүхбаатарын тухай кино үзье гэж урихад нь дараа больё гэхэд энэ кино маш чухал хэмээн шаардаж машинд суулган нэгэн харш маягийн байшинд аваачжээ. Ингээд Вандан “Дэмчигдонров чамайг манай нам засгаас дайсан этгээд гэж үзсэн тул даруй баривчилна” гэж мэдэгджээ. Тэднээс учир шалтгааныг асуумаар санагдсан боловч ийм нөхцөлд ямар ч ашиггүй гэдэг нь ойлгомжтой болсон тул тэр огт эсэргүүцэл үзүүлсэнгүй. Энэ агшинд Дэ ван “өчигдрийн хүндэт зочин өнөөдрийн нүгэлт дайсан нь боллоо доо” гэж ихэд харамсан боджээ.

ТЕГ-ын архивт байгаа М-591 дугаартай мөрдөн байцаалтын хэрэгтэй танилцахад түүнийг дайчлан баривчлах тогтоолд “...Дэмчигдонровын бие нь хөрөнгөтөн улсын ашиг тусын төлөө ардчиллын эсрэг явуулах хорт ажлуудыг удирдан толгойлж байсан дайсан этгээд болох учир... уг хэрэгт нь дайчлан баривчилж мөрдөн байцаалтыг явуулах саналыг төлөвлөв.” (3, т 3) гэж дурдсан байна. Баяр (ДЯЯ-ны орлогч сайд Очирбат) түүнийг 3-р сарын 1-нээс эхлэн нууцаар байцааж эхлэв. Түүнийг 9-р сарын 18-ны өдөр хүртэл хагас жил гаруй байцаахдаа тоо томшгүй олон асуудлыг хөндөн асууж, хариултыг нь тэмдэглэн авч байжээ. Япончуудтай хамтран ажиллаж байсан тухай асуудлаар байцаахдаа Баяр түүнээс “Японы тагнуул явсан үйл хэргээсээ ярь” гэхэд нь Дэ ван “Чи хэрэв намайг японы тагнуул гэж үздэгт хүрвэл би толгой унасан ч зөвшөөрөхгүй. Харин намайг тэдэнтэй сүлбэлдсэн тухайгаа ярь гэвэл болно” гэж хариулахад “тийм бол чи ярь” гэсэн байна. (4, т 32)

Түүнийг байцааж байх хугацаанд Дотоод явдлын яамны сайд Дуйнхоржав, орос зөвлөхийн хамт нэг удаа ирэхдээ “Чи шударгаар

мэдүүлэхгүй байгаа учир ял гэмийг чинь тодорхой мэддэг хүмүүсийг дуудаж нүүрэлдүүлнэ. Чамд хэлэх үг байна уу?” гээд Ли Шоусинь, Тогтох, Дагва-Осор гуравыг оруулж иржээ. Ли Шоусинь “Дэмчигдонров Монгол хязгаарын засгийн газрын үед дотоод гадаад Монголыг нэгтгэхээр санаархсанаар үл барам Зөвлөлтийн хил доторхи Буриад Монголыг ч багтаасан их Монгол улсыг байгуулж, өөрөө хаан суух гэсэн юм” гэсэн байна. Гэтэл ийм мэдүүлгийг түүнд зааж өгч бэлдүүлээд хэлүүлсэн байжээ. Дараа нь Тогтох “Японы эзэрхэг түрэмгийчүүд Дэмчигдонровтой сүлбэлдэн хуурмаг Монгол хязгаарын засгийг байгуулж, Монгол хязгаараар цэргийн суурин газар болгож, БНМАУ болон ЗХУ-ыг дайрахаар санаархаж байлаа. Хэрэв намайг нарийвчлан мэдүүл гэвэл би бүгдийг ярьж чадна...” гэж мэдүүлжээ. Хамгийн сүүлд Дагва-Осор “Дэмчигдонров бол “Монголын залуучуудын холбоо”-ны гол чухал гишүүн мөн...” гэж гэрчилсэн байна. Түүнийг шударгаар мэдүүлэхгүй бол дахин арван таван хүн авчирч тулган асууна гэж сүрдүүлсэн бөгөөд сүүлд нь Дэ ван өөрийн санаачилгаар мэдүүлэг өгсөн тул тэдгээр хүмүүсийг дуудсангүй ажээ. (4, т39) Дэ вантай хамтран ажиллаж байсан олон хүнээс мөрдөн байцаалтын явцад мэдүүлэг авсан байна. Түүний мөрдөн байцаалтын хугацааг 6 удаа сунгасан байх ба нийт 30 гаруй удаа байцаасан 2 хавтас 300 гаруй хуудас бүхий материал байна.

Наймдугаар сарын дунд үеэр ДЯЯ-ны нэгэн хошууч Дэ вангийн мэдүүлсэн зүйлсийг бүгдийг нь дахин нэг хувь хуулан бичээд түүнийг дуудан гарын үсэг зуруулах гэжээ. Гэтэл түүнд нь буруу зөрүү зүйл нэлээд байсан бөгөөд түүнийг бүр манай улсын хилд зугтан орж ирж баривчлагдсан гээд Хар эрэг болон Цагаан толгойд хоёр удаа уулзалт хийснийг огт дурдаагүй байлаа. Тэрээр маргалдаад ямар ч амжилт олохгүй гэж үзээд тэдний бичсэн бүх зүйлд нь гарын үсгээ зуржээ. Дахин ингэж гарын үсэг зуруулж байгаагаас тэр өөрийг нь хятадад буцааж өгөхөөр бэлтгэж байгаа юм байна гэж таамагласан байна.

Монгол-Зөвлөлтийн цэрэг 1945 онд Шилийн голд орж ирэх үед Чуулалт хаалгаас дэслэгч-генерал Тэгшбуян нэг салаа цэргийн хамт Сенид баруун хошуунд ирж, холбогдох хүмүүсийг оролцуулан яаралтай хурал хийж, Дэ вангийн зааврыг танилцуулсан байна. Тэрээр Сенид баруун хошууны ноёд түшмэд болон цэргийн дарга нар бүгдээрээ Тогоот сүмд шилжин очихын хамт их хүү Дугарсүрэн өөрийн биеэр хариуцан бүх гэр бүлээ ч тийш аваачиж, улмаар цаашид Гүл хөхийн элсэнд очих, чуулганы дэд дарга Будбалд уламжлан Шилийн голын чуулган яамны хүмүүсийг ч Гүл хөхийн элсэнд очуулах, Монгол-Зөвлөлтийн цэрэгтэй тулалдаан хийж, зэвсэг хөдөлгөж огт болохгүй, хошууны цэргийг элсэнд шилжүүлж оруулах хэрэгтэй гээд өөрөө

Чуулалт хаалгад байгаа монгол цэрэг, дарга нартайгаа тэдэн дээр хүрч очихоор төлөвлөж байгаага мэдэгдсэн байжээ. (7, т14) Ингээд тэд Тогоот сүмд очоод удаагүй байхад нь манай цэргийнхэн гэр бүлийнхнийг нь ордондоо ир гэж дуудуулан хамгаалалтад авсан бөгөөд их хүү Дугарсүрэн нарын хэдэн хүнийг Улаанбаатарт төлөөлөгчөөр ирүүлжээ. Есдүгээр сард маршал Х.Чойбалсан Сенид баруун хошуунд очихдоо Дэ вангийн хатан болон хүүхдүүдийг нь хүлээн авч уулзсан бөгөөд дараа нь Дугарсүрэн тэднийг Улаанбаатарт ирээрэй гэж хэлүүлсэн байна. Рэнчинцоо хатан манай улсад явахыг хүсэхгүй байсан боловч Алтан-Очир түүнийг ятгаж, Лувсан хурандаа зэрэг хүмүүс тэднийг авч явах л болно гэж ярьж байна гэх зэргээр нөлөөлсөн тул зөвшөөрсөн байна. Тэднийг манай улсад ирэхийн өмнө хожим нь ӨМӨЗО-ны тэргүүлэгч болсон Улаанхүү ирж, Дэ вангийн хатантай уулзсан бөгөөд түүнээс нөхөртөө захидал бичиж ятган нутагт нь буцааж ирүүлэхийг хүссэн байна. Их хүү Дугарсүрэн захиа ирүүлж, гэр бүлээрээ Улаанбаатарт ир гэж байгаа тухай Улаанхүүд хэлэхэд тэрээр хүүхдүүдээ тэнд аваачиж ном сургах нь тун зөв гэж хэлж байжээ. (7, т 20-21)

Дэ вангийн гэр бүлийнхнийг Улаанбаатарт 1945 оны 11-р сарын эхээр авчирч, тусгай хашаа байшинд асрагч, тогооч зэрэг дагалдан очсон хүмүүсийн нь хамт байрлуулсан байна. Ирсэн хүмүүс нь Дэ вангийн хатан Рэнчинцоо, хүү Дугарсүрэн, Галсанжигмэд, Очирбат, Очирхуяг, охин Батнасан, бэр Сэржмядаг, ач хүү Насан-Өлзий, Баатар-Өлзий нар болно. Их хүү Дугарсүрэн нь Намын шинэ хүчний дээд сургуульд суралцаж байсан тул сургуулийнхаа байранд сууж байв. Тэдэнд сайд нарын гэгдэх 18 дугаар дэлгүүрээр үйлчлүүлэх үнэмлэх олгож, сайдын хэмжээний хангалт олгож байжээ. Хойтон жил нь тэдний малыг аваачсан бөгөөд түүнээсээ хоёр зуу шахам бод, гурван зуу гаруй бог, нийт таван зуугаад толгой малыг манай улсын засгийн газарт бэлэглэсэн байна. Удалгүй хоёр дахь хүү Галсанжигмэд, охин Батнасан болон Дугарсүрэнгийн эхнэр Сэржмядаг нарыг мал тууж ирсэн хэсэг хүмүүсийн хамт Багшийн сургуульд нэг анги болгон суралцуулж эхэлжээ. Очирбат, Очирхуяг нар нь 1947 онд арван жилийн нэгдүгээр дунд сургуульд суралцаж эхлэв. Галсанжигмэд сургуулиа төгсөөд Мал эмнэлгийн тусгай мэргэжлийн сургуульд багшлахын зэрэгцээ оройгоор дээд сургуульд сурч, Сэржмядаг арван жилийн 11 дүгээр дунд сургуульд, Батнасан 5 дугаар дунд сургуульд бага ангийн багшаар ажиллах болов. Дугарсүрэн мөн сургуулиа төгсөөд МУИС-д амжилттай суралцаж, онц сурлагатны шагнал авч байлаа.

Гэтэл 1950 оны 10-р сарын 15-нд ДЯЯ-ны ажилтнууд ирж, гэр орныг нь нэгжиж, авдарт байсан үнэт эдлэл, торго зэрэг эд зүйлсийг

нь хураан авч, маргааш өглөө нь гэрийг нь машинд ачин Рэнчинцоо, Батнасан, Очирбат, Очирхуяг болон мал тууж ирээд эднийд сууж байсан Равжаа нарыг суулган Улаанбаатраас баруун зүг хөдөлсөн байна. Мөн Сэржмядагийг нялх хүүхдүүдтэй нь хамт нэг машинаар авч явжээ. Галсанжигмэдийг оройн сургуулийн хичээлдээ сууж байхад нь баривчилсан бөгөөд Дугарсүрэнг мөн энэ орой нь ДЯЯ-ны орлогч сайд Баяр (жинхэнэ нэр нь Очирбат) өөрийн биеэр гэрт нь очиж баривчилсан байна. (7, т29) Тэднийг ДЯЯ-ны Архангай аймаг дахь хэлтсийн байранд хоёр хонуулаад төлөөлөгч Минжүүр (хожим нь хөдөлмөрийн баатар болсон) тус аймгийн Хан-Оюут (одоогийн Эрдэнэмандал) сумд хүргэж, хэсгийн төлөөлөгч Жигжидтэй танилцуулж, түүнд хариуцуулж өгсөн байна. Энэ суманд дунд сургууль байгаагүй учир Эрдэнэмандалын сургуульд хүүхдүүдээ явуулья гэсэн боловч зөвшөөрөөгүй байна. Ингээд амьдралаа аргацаахын тулд хоёр эмэгтэй нь хүмүүст юм оёж өгөх, Равжаа Очирбат нар түлшний мод бэлтгэх, хонь хайчлах зэрэг аль тааралдсан ажлыг хийж байв. Заримдаа түймэр унтраах зэрэг цаг үеийн ажилд дайчлагдан, тайлан тооцоо гаргах зэрэг бичиг цаасны ажилд туслах зэргээр амь зууж байжээ. Тэд нутгийн хүмүүстэй эвтэй найртай амьдарч байтал 1953 онд Архангай аймгийн төвд шилжиж суухыг зөвшөөрсөн тул үхэр тэргээр нүүж ирсэнд шууд Улаанбаатарт машинаар хүргээд нэгэн хашаанд буулган гадагш гарахыг нь хорьж цагдаагаар харгалзуулсан байна. Хоёр хоногийн дараа Төв аймгийн Галбадрах суманд нутаг заагдан сууж байсан Сэржмядагийг дөрвөн хүүхдийн нь хамт авчраад тэднийг нутагт нь буцаахаар болсныг дуулгажээ. Эх нь хоёр хүүтэйгээ уулзаж, хамт буцна хэмээн эрс шаардаж, үүнийг нь биелүүлэхгүй бол амиа хорлоно гэсэнд ДЯЯ-ны орлогч сайд Очирбат (Баяр) тэднийг эх орондоо буцчихсан гэж хэлсэн байна. (7, т 46)

Манай Дотоод явдлын яам Дэмчигдонров овогтой Дугарсүрэнгийн 12904 тоот мөрдөн байцаалтын хэргийг 1950 оны 10 дугаар сарын 12-нд нээж, 1951 оны 12 дугаар сарын 30-нд хааж шийдвэрлэсэн байдаг. Мөрдөн байцаалтын хугацааг 14 удаа сунгаж, Дугарсүрэнг нийт 130-аад удаа байцаан 1316 хуудастай 5 хавтаст хэрэг бүрдүүлжээ. Хэргээс үзвэл “Дугарсүрэн 1918 онд төрсөн, 1945 он хүртэл Сөнид баруун хошууны ноёны тушаалд ван зэрэгтэй явсан, 1944 онд уг хошууны хилийн сэргийлэх хорооны даргаар дэд хурандаа цолтой ажилласан, 1939 ба 1944 онуудад Токио хотод юм үзэх ба курс хийхээр очиж байсан, 1945 онд тус улсад ирээд шинэ хүчний дээд сургуульд сурч төгсөөд Улсын их сургуульд элсэн хэлбичгийн ангид суралцаж байсан, ам бүл 11, лам яваагүй, гишүүн бус, япон, хятад, монгол, англи хэл бичиг мэднэ. Холбогдох материал



нь: “Дугарсүрэн нь Сөнид баруун хошууны ноён байхдаа Японы идэвхтэй тагнуулчин болж, уг хошууны ард түмнийг тагнаж байснаас гадна Монгол улсын эсрэг тагнуулын ажлыг хүчтэйгээр явуулж, Японы эзэрхийлэн түрэмгийлэх явдалд нь тусалж байсан этгээд болох ба мөн тус улсад 45 онд ирснээс хойш янз бүрийн худал гүтгэлгийг тарааж, хөрөнгөтний харгис хүчнийг магтах буюу ардчилсан улсыг муучлах явдал нь тасралтгүй болжээ...” гээд түүний талаар олон гэрчийн мэдүүлгүүдээс дурдаад Эрүүгийн хуулийн 62, 66 дугаар зүйлүүдэд заасан гэмт хэргүүдийг үйлдсэн гэдгээр 1950 оны 10-р сарын 12-нд баривчилсан байна. Ингээд түүнийг жил гаруйн хугацаанд 138 удаа байцааж, маш олон гэрчийн мэдүүлгүүдийг авсан ба хоолыг нь хасах, 20 гаруй цаг кастерт хорих зэргээр дарамтлан байцааж үндэслэлгүй хэрэг тулган хүлээлгэж байсан нь нотлогдсон байдаг. Мөн зарим мөрдөн байцаагч нь худал рапорт бичих, түүнийг бусдаар гүтгүүлэх зэрэг аргыг хэрэглэж байгууллагын нэр хүндийг олон түмэнд алдагдуулах хортой асуудлын эх үндсийг тавьсан зэрэг завхрал гаргаж байсныг тэмдэглэсэн байна. (2, 5-ын т 215) Дугарсүрэнгийн идэвхтэй тагнуулчин болох нь хэрэгтэн Тогтох, Гомбожав, Алтан-Очир, Бат-Очир зэрэг хүмүүсийн мэдүүлгээр батлагдсан гээд энэ хэрэгт нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 62 дугаар зүйлд зааснаар ял төлөвлөсөн бөгөөд ДЯЯ-ны тусгай комиссын 1952 оны 1-р сарын 5-ны 1 дүгээр хурлаар буудан алах ялаар шийтгэсэн байна. Дэмчигдонровоор толгойлуулсан БНМАУ-ын эсрэг тагнуул хийх, цуурхал тараах, зэвсэгт бослого гаргах, алан хядах, хорлон сүйтгэх эсэргүү байгууллагыг 20 гаруй хүнтэйгээр байгуулсан гэдэг нь худал болох нь тогтоогдсон. (2, 5-ын т 261)

Дотоод явдлын яамны 1079 тоот мөрдөн байцаалтын хэргээс үзвэл Д.Галсанжигмэд 1928 онд Шилийн голын чуулганы Сөнид баруун хошууны Наран булагт Дэмчигдонровын 6 дахь хүү болон төрсөн, эх Эрэнцэнцоогийн гар дээр хүмүүжиж, 17 нас хүртлээ монгол бичиг, түвэд ном заалгаж байв. 11 настайгаасаа Сөнид баруун хошуун дахь Банчин богдын сүмд сууж байхдаа ноёны хүү гэдгээр хувилгааны суудалд сууж байжээ. 1945 оны 10-р сард Улаанбаатарт ирж, 1946 оны 9-р сараас Багшийн сургуульд сурч 1949 оны хавар төгсөөд баригдах хүртлээ Мал аж ахуйн техникумд багшилж байв. Д.Галсанжигмэдийг 1950 оны 10-р сарын 12-нд баривчилж, ДЯЯ-ны дэргэдэх Тусгай комиссын 1951 оны 4-р сарын 29-ний хурлын тогтоолоор тус улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 66 дугаар зүйлийн 1-д зааснаар 10 жил хорих ялаар шийтгэжээ. Дайчлан баривчлах тогтоолд “Энэхүү Галсанжигмэд нь Дотоод Монголд хувилгаан лам байсан ба Монгол улсад ирснээсээ хойш манай нам

засгийн эсрэг цуурхал, гүтгэлэгийг гаргаж байдаг байна. Баримтыг дурьдваас: 1. Би оройн дээд сургуульд явдаг. Хар үст чөтгөрийн сургаал гэж маш бэрх юм байна. Хар үсийг нь тоолохоос хэцүү юм. Үүний шалгалтыг яаж өгдөг билээ гэж Марксыг хар үст чөтгөр гэж хэлж байсан ба түүний сургаалыг судлахаас бэрхшээж, доромжилж байсан. 2. Монголын “Эх орон” гэдэг дууг гуйвуулан дуулж байсан Энэ мэтийн гүтгэлэг доромжлолыг удаа дараа тарааж байсан явдал нь батлагдсан.” гэж дурдсан байна. (1, т3) Түүнийг 16 удаа байцааж хэргийг хүлээлгээд 10 жил хорих ял зааж, түүнээс 5 жилийг гянданд хорьж, үлдэх 5 жилийг хөдөлмөрийн лагерьт хорихоор шийдвэрлэжээ. (1, т 129)

Дэ ванг манай ДЯЯ-ныхан 1950 оны 9-р сарын 18-нд хоёр гарыг ард нь хүлж, нүдийг нь хар даавуугаар битүүлээд гяндангаас гаргаж, машинд суулган онгоцны буудалд хүргэжээ. Ингээд түүнийг шууд онгоцонд суулган Бээжинд аваачсан байна. Бээжингээс Чуулалт хаалгад шилжүүлэн хорьсон байна. Гэр бүлийнхнийг нь манайхан 1953 оны 6-р сарын эхээр машинаар Чойбалсан хотод хүргэж хорь гаруй хонуулаад Хөлөнбуйр аймгийн Шинэ барга баруун хошууны нутаг дахь хилийн боомтоор хятадын талд хүлээлгэн өгчээ. Хятадын тал тэднийг Манжуурт хүргэж, галт тэргээр Улаанхалад аваачин суурьшуулсан байна. Сэржмядаг, Батнасан нарыг Улаанхад хотын монгол дунд сургуульд багшлуулж, хоёр хүүг нь дунд сургуульд оруулаад Чанрав, Равжаа нарыг Монголоос очсон бусад хүмүүсийн хамт Сенид баруун хошуунд нь буцаасан байна. Дараа нь тэднийг Хайлаарьт шилжүүлэн суулгаж, ажил сургуулийг нь зохицуулж өгсөн бөгөөд тэндээс нь 1957 онд Шилийн хот руу нүүлгэжээ. Энэ үед хүү Очирбат нь дунд сургуулиа төгссөн боловч гарал муу гэсэн шалтгаанаар дээд сургуульд оруулсангүй тул Хөлөнбуйрын дуу бүжгийн бүлгэмд ажилд орох гэсэнд мөн зөвшөөрсөнгүй.

Галсанжигмэдийг 1955 онд манай улсаас ялтнаар хятадын талд хүлээлгэн өгсөнд Дотоодыг хамгаалах байгууллага нь хянаж үзээд ялгүй хэмээн суллаж, Хөххотын үндэстний хоёрдугаар багшийн сургуульд ажиллуулжээ. (7, т63) Очирбат нь Өвөр Монголын Урлагийн сургуульд суралцаж 1959 онд төгсөөд жүжгийн чуулгад ажиллаж эхлэв. Энэ үед Очирхуяг нас барж, Галсанжигмэд Баяннуур аймагт шилжин ажиллах болсон тул ээж болон бэр Сэржмядаг, түүний хүүхдүүдийг харж хандах хүнгүйгээс Очирбат Шилийн хотод шилжин хөгжимчнөөр ажилласан байна. Гэтэл дараахан нь түүнийг мөн гарал муу гэдэг шалтгаанаар ажлаас нь халж, Ялалт нэгдэлд 1961 он хүртэл ажил хийлгэжээ. Түүний гэр бүл болохоор тохиролцсон бүсгүйг мөн ийм шалтгаанаар салгаж, амьдралыг нь бусниулсан байна.

Өвөр Монголын Дотоодыг хамгаалах тэнхимээс 1962 онд Очирбатыг ээжтэй нь хамт дуудан уулзаж, аав нь элэгний хүнд өвчнөөр өвчилсөн боловч эмнүүлээд гайгүй болсон тухай яриад гэр бүлийнхэнтэй нь уулзуулахаар шийдсэнийг хэлжээ. Тэд албаны хүмүүсийн хэлж өгсөн зүйлүүдийг ихэвчлэн ярьж, амар мэндээ мэдэлцээд эхний уулзалт өндөрлөжээ. Тэндэхийн ажилтнууд “...аав чинь өөрийгөө ялтай гэж хэлүүлэх тун дургүй. Энэ талаар бидэнтэй маргалдаад ууралдаг юм шүү” гэж ярьсан байдаг. Дараа нь тэднийг Дотоодыг хамгаалах тэнхимийн холбогдох хүмүүс дуудан уулзаж гэрээр “даан авч эмчлүүлэх”-ийг намын хорооноос зөвшөөрсөн гээд батлан даалтад гаргасан байна. Тэднийг Өвөр Монголын Эмнэлгийн дээд сургуулийн харьяа эмнэлэгт хэсэг хугацаанд байлгаад 1962 оны 10-р сарын 1-нд тусгай байранд шилжүүлэн оруулжээ. Гэр бүлийн гурав ийнхүү хамт суух болж, амьдралдаа тохиолдсон бэрхшээл зовлонгоо ярилцан ойлголцож сэтгэл уужирсан боловч Дугарсүрэнгээс ямар ч сураг гарахгүй байлаа.

Өвөр Монголын Ардын дээд шүүхийн хурлын танхимд 1963 оны 4-р сарын 9-нд хийсэн хурлаас Дэмчигдонровт “БНХАУ-ын Дээд шүүх хорооны онц уучлалын бичиг”-ийг гардуулан өгч, хүү Очирбатаар нь талархлын үг хэлүүлж ёслол үйлдсэн бөгөөд Намын хорооны дэд нарийн бичгийн дарга бөгөөд Дотоодыг хамгаалах Тэнхимийн дарга Билэгбаатар үг хэлсэн байна. Түүнийг эхнэр, хүүгийн нь хамт Дотоодыг хамгаалах Тэнхимийн холбогдох хүмүүс гэрт нь хүргэж өгөх үед тэрээр “...Би та нарын үгийг хүлээн сонсохгүй мугуйдалсаар энэ өдөр хүрчээ. Даанч оройтлоо доо” гэж хэлсэн байна. (7, т 111) Дараа нь түүнд Өвөр Монголын Соёл, түүхийн хүрээлэнд ажиллахыг урьсан Улаанхүүгийн захидал болон тэнд санчаар томилсон мэдэгдлийг гардуулж өгсөн байна. Уг хүрээлэнгийнхэн түүнийг халуун дотноор хүлээн авсан бөгөөд хуучны хэд хэдэн танилууд нь ч тэнд ажиллаж байв. Тэд гуч, дөчөөд оны түүхэн явдлуудыг шүүн ярилцаж, тэмдэглэл хийхээс гадна сургалт, хүмүүжлийн ажилд оролцдог байжээ.

Дэ вангийн дурсамжид “...Над шиг тэнгэр тулам ял хөнөөлтэй, улсаасаа урван тэрсэлж, гадаадад зугтан баривчлагдаад улсдаа буцаагдсан хүнд ялтанд зохих ялыг нь ногдуулж, олбоос зохих шийтгэлийг олгох нь өчүүхэн төдий ч хилсгүй явдал юм. Гэтэл БНМАУ-аас намайг баривчлахгүй байсан ба баривчилсны дараа намайг улсад нь буцаан хүргэхгүй мөртөө миний гэр бүлийг ч улсад нь буцаасангүй. Харин хэрэг учрыг төсөөлж мэдэхгүй нялх балчир хүүхдийг минь хүртэл хамгийн хүйтэн газарт цөлж, хал зовлонг ханатал амсуулсан нь надад даанч хэтэрчихсэн гэж санагдаад байна. Би японы эзэрхэг түрэмгийтэн, гоминьданы тэрслүү засгийн газар ба америкийн эзэрхэг түрэмгийтний

тэрслүү замаар замнаж, “Их монгол үзэл”-ийн зэрлэг санаагаа биелүүлэхээр горьдов. Энэ удаа бас БНМАУ-д хүрч, эх улсын нэгдэл, үндэстний бүлгэмдлийг хагацуулах хуйвалдаан хийхээр санаархсан явдал бол буруудсан дээрээ буруудаж, тэрслүү дээрээ улам тэрслүү замаар замнасан явдал болно” (5, т 824 ) гэх зэргээр бичжээ. Мөн “...Би бол Шилийн голын чуулганы засаг барьж байхдаа ард түмнийг мөлжин ноёрхсон феодалын ван гүн мөн. Хуурмаг Монгол хязгаарын үед бол японы дээрэмчидтэй сүлбээлж, ард түмэнд цуст ноёрхол явуулсан хамсаатан мөн. Алаша хошуугаар дамжин дутааж байхдаа цэрэг талбиж, ардыг зовоосон дээрмийн толгойлогч мөн гэж танив. Миний хийсэн ял бол туйлын хүнд ноцтой бөгөөд тоолоод баршгүй билээ... Монгол үндэстэнд авч хэлбэл, би бол нэгэн уучилж болшгүй хүнд ялтан. Дундадын үндэстэнд авч авч хэлбэл үхэвч үл илүүдэх үндэстний шаар, улсаа худалдагч мөн” (8, т450) гэсэн байдаг нь үзэл сурталжсан зохиол юм.

Дэмчигдонров хоригдож байхдаа “Монгол, манж, хятад хэлний харьцуулсан толь” бичиж, Дотоодыг хамгаалах тэнхимээр дамжуулан Өвөр Монголын Хэл бичиг судлах газарт хүргүүлсэн байна. Хүрээлэнгийн удирдлага Дэ вангийн нарийн бичээчдийн нэг байсан Түвшинг түүнд туслалцуулахаар томилон ажиллуусан байна. Тэр хоёр бараг өдөр бүр хамт сууж, Өвөр Монголын гуч, дөчөөд оны байдлыг шүүн ярилцаж, Дэмчигдонровын ярьсныг Түвшин тэмдэглэн авах байдлаар гурван жил ажилласан байна. Тэрээр мөн “Ван гүнгүүдийн шарах ёсон” гэсэн нэртэй ёс заншлын тухай танилцуулга бичихийн хамт дээр дурдсан толь бичгээ ч засч, цаг алдахгүйг хичээн өдөр шөнөгүй сууж, шамдан ажиллаж байв. Гэтэл бие нь муудаж эхэлсэн тул Өвөр Монголын Эмнэлгийн дээд сургуулийн харъяа эмнэлэгт хэвтэж шинжилгээ хийлгэхэд өвчин нь хүндэрч, элэгний хорт хавдар болсон байжээ. Тэрээр 1966 оны 5-р сарын 23-нд таалал төгссөн байна.

Хүүхдүүд нь түүний гэрээс ёсоор төрсөн нутагт нь оршуулахаар төлөвлөж байсан боловч боломж олдоогүй тул Хөххотын оршуулгын газарт чандрыг нь нэг жилийн хугацаагаар хадгалуулах болжээ. “Соёлын хувьсгал”-ын үед улаан хамгаалагчид оршуулгын газарт байсан баяд ноёдын чандрыг устгахад тэндэхийн нэг ажилтан түүний чандрыг нуун авч үлдсэнийг хүү Очирбат нь гэртээ хадгалж байгаад 1976 онд Шулуун хөх хошууны нутагт шилжүүлж, дараа нь 1990 оны 10-р сард Баруун Сөнид хошууны Дүүрэн өлзий сумын нутаг Алтан овооны энгэрт дээдсийн нь онгоны дэргэд оршуулсан байна.

“Соёлын хувьсгал”-ын үед ээжийнхээ хамт Хөххотод сууж байсан хүү Очирбатыг нь “Үндэстнийг хагацуулагч этгээд”, “Монголын тагнуул”

гэх зэрэг нэр зүүн хорьж, олон сараар тамлан байцаасан тул эрүүл мэнд нь муудаж, үхэхийн даваан дээр эмнэлэгт хүргэгдэн амь мултарсан байна. Энэ үеэр орон гэрийг нь нэгжин түйвээж эхэлсэн тул аавынхаа туурвисан “Монгол-хятад-манж хэлний харьцуулсан толь”-ийг Дотоодыг хамгаалах Тэнхимийн тавдугаар газарт хадгалуулсан бөгөөд хожим нь буцааж авах гэхэд олдохгүй байна гээд өгөөгүй гэдэг. Тэдний сууж байсан байшинг хураан авч, нэг өрөөтэй байшин олгосон байна. Дараа нь тэднийг Шилийн хот руу хөөн явуулжээ.

Энэ үеэр Шилийн голд сууж байсан отгон хүү Очирсахьяа нь цэл залуугаараа учир битүүлгээр нас барж, хүүхдүүд нь өнчрөн үлдэв. Удалгүй сэтгэл санааны олон хүнд дарамтад байсан эх Рэнчинцоо нь нас барлаа. “Соёлын хувьсгал”-ын үед ажлаасаа халагдан сэтгэл санаа, аж амьдралдаа хүнд цохилт амсаад байсан охин Батнасан нь ээж дүү хоёрынхоо тухай сонсоод тархинд нь цус харвасны улмаас 1969 оны 8-р сард мөн нас барсан байна. Ингээд ганцхан жилийн хугацаанд эдний халуун ам бүлийн гурван хүн нас барж, хоёр хүү нь л үлдэв. (7, т 143)

“Соёлын хувьсгал”-ын дараа Очирбат нь Өвөр Монголын урлагийн байгууллагуудад хөгжмийн мэргэжлээрээ ажиллаж, амьдралын хүнд бэрх зовлонг туулах явцдаа зүрхний хүнд өвчтэй болсон тул 1978 онд Бээжинд мэс засал хийлгэсэн нь амжилттай болов. Ингээд 1980 оны сүүлээс Өвөр Монголын Урлагийн дээд сургуульд ажиллаж байгаад 1994 оны 9-р сард 60 настайдаа тэтгэвэртээ гарсан байна.

Хоёрдахь хүү Галсанжигмэд нь Шилийн гол аймагт багшийн ажил хийж байсан бөгөөд хожим нь Өвөр Монголын Ардын төлөөлөгчдийн их хурлын төлөөлөгч болж, Шулуун хөх хошууны Улс төрийн зөвлөлгөөний дэд тэргүүдэгчээр ажиллаж байгаад 2001 онд нас барсан байна. Энэ хүн “Соёлын хувьсгал”-ын үед мөн хэлмэгдэн зовж байсан.

Д.Очирбат гуай манай улсаас хүргэгдээд 36 жилийн дараа буюу 1989 оны 7-р сард Улаанбаатарт ирж, хуучин танилууд болон хамт сурч байсан хүмүүстэйгээ уулзаж, ахынхаа талаар сураглан түүнийг цаазлагдсан тухай анх удаа сонссон байна. Дараа жил нь улс төрийн хэрэгт хэлмэгдэгсэдийг цагаатгах ажлыг зохицуулах комисс байгуулагдсан тухай сонсоод 1950 оноос хойш сургийг нь сонсоогүй ахынхаа талаар тодорхой өргөдөл бичиж, хүнээр дамжуулан уг байгууллагад ирүүлсэн байна.

1991 оны 11-р сард Улсын Дээд шүүхийн Цэргийн коллегийн 10-р сарын 5-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор ах Дугарсүрэнг нь улс төрийн гэмт хэрэгт холбогдолгүй болохыг тогтоон цагаатгасан

үнэмлэх олгосон байна. Улсын Дээд шүүхийн мөн оны 12-р сарын 18-ны 195 дугаар тогтоолоор ах Галсанжигмэдийг нь бас цагаатгаж, үнэмлэх олгожээ. (7, т212)

Д.Очирбат гуай 1998 оны 10-р сард япончуудын урилгаар Токиод очиход Парламентын дарга нь хүлээн авч уулзсан бөгөөд Япон-Монголын найрамдлын нийгэмлэг болон олон нийтийн хэд хэдэн байгууллагаар орж, аавын нь зөвлөхөөр ажиллаж байсан 92 настай Накажиматай уулзсан байна. (31, т223) Түүнийг мөн Осака хотод зочлуулж, тэнд ажиллаж, сурч буй монголчуудтай уулзуулж, олон газраар явуулжээ. Д.Очирбат гуай одоо Хөххотод гэргий, охин, зээ хүүгийн хамт сууж байна.

Дэ ванг манай улсад ирүүлэхэд чиглэсэн ажиллагааг манай ДЯЯ чөлөөлөх дайны үеэс төлөвлөж эхэлсэн бололтой. Энэ ажилдаа түүний ойрын садан Алтан-Очир гүн зэрэг нэр бүхий хүмүүсийг ашиглаж байсан баримт бий. Түүний гэр бүлийнхнийг болон хүү Дугарсүрэнг гэрийнхний нь хамт Улаанбаатарт ирүүлсэн нь ч үүнтэй холбоотой гэж үзэж болно. Дугарсүрэнг манайхан энэ ажилдаа идэвхтэй ашигласан байдаг. Дэ ван хоёр Монголыг нэгтгэх асуудалд маршал Чойбалсангийн дэмжлэгийг авч, буцаж очоод АНУ-ын тусалцаатайгаар цаашид тэмцлээ үргэлжлүүлж болох байх гэсэн горьдлого өвөртөлж Улаанбаатарт ирсэн байна. Гэтэл манайхан түүнийг ялтан болгон хорьж байцаагаад зогсохгүй хоёр хүүг нь баривчлан шийтгэж, гэр бүлийнхнийг нь нутаг заан цөлсөн нь үнэхээр харамсалтай. Энэ хоёр гэр бүлийнхнээс Дугарсүрэнг цаазалж, дүүг нь арван жилийн хорих ялаар шийтгэсэн нь нь хэлмэгдүүлэлтийн дээд хязгаар гэлтэй. Дараа нь тэднийг Хятадын талд шилжүүлэн өгсөн ч Дэ ванг арван гурван жил засан хүмүүжүүлэх газарт хүмүүжүүлээд бие нь муудахад нь уучлал үзүүлж сулласан боловч гурван жилийн дараа нас барсан байна. Соёлын хувьсгалын үеэр эхнэр, хүү, охин гурав нь ганцхан жилийн дотор нас барж, үлдсэн хоёр хүү нь монголын тагнуул хэмээн цоллуулж тамлуулж байв. Эндээс харахад түүний гэр бүлийнхний хэлмэгдэлд манайхан багагүй буруутай нь тодорхой байна.

**ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ**

1. Д.Галсанжигмэдийн мөрдөн байцаалтын хэрэг ТЕГ ТА ХН Ц 2041
2. Д.Дугарсүрэнгийн мөрдөн байцаалтын хэрэг ТЕГ ТА ХН Ц 2039
3. Н.Дэмчигдонровын мөрдөн байцаалтын хэрэг ТЕГ ТА ХН М591
4. Н.Дэмчигдонров. “БНМАУ-д очсон миний өнгөрөлт” Хөххот 1984
5. Лу Минхуй. “Монголын “өөртөө засах хөдөлгөөн”-ий үүсэл төгсөл” Хөххот 1986
6. Lu Minghui “De wang qi ren” Huhe haote 1998 (Лу Минхуй “Дэ ван гэдэг хүн” Хөх хот 1998)
7. Д.Очирбат. “Дэмчигдонровын Очирбат” Хөххот 2003
8. Түвшин. “Дэмчигдонровын тоочилт”.Өвөр Монголын түүхийн материалын 13 дугаар эмхэтгэл 1991
9. Таобухин “Demuchukedonglupu zishu”. Huhe haote 1984 (“Дэмчигдонровын өчил” Хөххот 1984)